

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Номгон сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2022/55/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn Өмнөговь аймаг Даланзадгад сум 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Сүрэнжаргал Утас: 70533552 Цахим хаяг: Surenjargald@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2022.02.23 № 154

танай _____-ны № _____-т

НОМГОН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.АЛТАНТУЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Номгон сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Номгон сумын цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэл, нормын хувцасны зардалд зарцуулсан 3,167,300 төгрөгийг шууд зардлаар бүртгэсэн, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2,678.800 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь үнэлгээ ба хуваарилалт, ангилалт, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

0130 11 10

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

СЦЭВЭНБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

	Үзүүлэлт	/сая төгрөгөөр/
	Эргэлтийн хөрөнгийн дүн	13.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	350.9
	Нийт хөрөнгийн дүн	364.3
	Нийт өр төлбөрийн дүн	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	364.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	364.3
	Үйл ажиллагааны орлогын дүн	214.2
	Үйл ажиллагааны зардлын дүн	235.8
	Үйл ажиллагааны үр дүн	-21.6
	Үйл ажиллагааны бус үр дүн	
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-21.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	385.9
	Тайлант оны үр дүн	-21.6
	Эцсийн үлдэгдэл	364.3
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	211.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	211.2
	Үйл ажиллагааны ЦМГ	0.5
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-0.5
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	188.5
	Урсгал зардал	
	Хөрөнгийн зардал	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17.6
	Улсын төсвөөс санхүүжих	170.9

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Номгон сумын цэцэрлэгийн эрхэм зорилго нь “Монгол ардын зан заншил өв уламжлалыг хүүхдэд багаас нь өвлүүлж, хүүхэд тоглонгоо суралцах орчин бүрүүлнэ. Хүүхэд бүрийн оюун ухаан, бие бялдар, нийгэмшихүйн чадамжийг хөгжүүлэн дэмжлэг үзүүлнэ” гэж тодорхойлжээ.

Үйл ажиллагааны чиглэл нь бага насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаа явуулдаг байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 246.8 сая төгрөгийн 35 мэдээллээс 35 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудалгүй байхгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 46.1 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн аудитын явцад 40.3 сая төгрөгийг залруулж, 5.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, ажил сайжруулах 1 зөвлөмж хүргүүлээ.

7.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардалд 0.5 сая төгрөг тусгаагүй, цалингийн өглөг дансыг цалингийн цэстэй тулган баталгаажуулахад 9.8 сая төгрөгөөр илүү, цалингаас суутгасан 26.6 сая төгрөгийн НДШ, ХАОАТ, ҮЭ-ийн татварыг тус тусын өглөг дансаар бүртгээгүй, цалингаас суутгасан урьдчилгаа 3.4 сая төгрөгийг зардлын дансанд шууд бичсэн.

7.2 Албан шаардлага

Бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэл, нормын хувцасны зардалд зарцуулсан 3.1 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэсэн, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

7.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Тооллого тооцоо

Илрүүлэлт:

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 11 дүгээр сарын 25-ний өдрийн А/18 дугаар тушаалаар хөрөнгийн тооллогын комисс байгуулан тооллого хийсэн боловч комиссын ажлын тайлан байхгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дах заатыг хэрэгжүүлэн зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

7.4 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		

7.5 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	4	46.1	2	40.3	0	0	1	5.8	1	0

2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	4	46.1	2	40.3	0	0	1	5.8	1	0